



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Үндэсний аудитын газрын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 136 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуульд нам, эвсэл болон сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг хавсралтаар баталсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

1524010015

Сонгуулийн ерөнхий хорооны  
2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
НАМ, ЭВСЭЛ БОЛОН НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН  
ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (МУИХСТ) хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2<sup>1</sup>-т заасан нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо энэхүү аргачлалыг баримтална.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үзэл баримтлалын дагуу сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэгдэх бөгөөд өмнөх сонгуулийн зардлын гүйцэтгэл, зах зээлийн бодит үнэ цэнийг харгалзан, энгийн ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, тооцооллын үндэслэл нь сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч, иргэд сонгогчдын сонгох эрхээ эдлэхэд аливаа хязгаарлалт үзүүлэхгүй байхад чиглэгдсэн байна.

**Хоёр. Нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтооход харгалзах хүчин зүйлс**

**2.1 Зардлын дээд хэмжээг тооцоолохын өмнө хийх урьдчилсан судалгаа**

Нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо дараах судалгааг хийсэн байна. Үүнд:

Хууль, эрх зүйн орчны судалгаа;

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.20<sup>2</sup>-д заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд нийцүүлэн баталсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам;

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9<sup>3</sup>-д заасан цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хороо хамтран баталсан Цахим орчныг ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам;

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, хэрэглээний үнийн индекс, инфляцын мэдээ зэрэг холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагуудаас дэлгэрэнгүй судалгаа (аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо);

Өдөр тутмын сонин болон сэтгүүлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн үнийн санал;

<sup>1</sup> 50.1.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө энэ хуулийн 50.2-т заасан аргачлалын дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ., 50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.

<sup>2</sup> 46.20.Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн, энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо батална.

<sup>3</sup> 47.9.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо хамтран баталж, мөрдүүлнэ.

Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн болон зурагт самбарын үнийн судалгаа;

Цахим орчин ашиглаж сурталчилгаа явуулахтай холбоотой зохих үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс үнийн санал;

Өмнөх ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон эрх зүйн акт;

Өмнөх ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын гүйцэтгэлийн тайлангийн архивын материал;

Улс төрийн намуудаас авсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын санал авч судалгаа хийсэн байна.

### **Гурав. Нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал**

Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн тоо, сонгогчийн тоо болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ.

Сонгуулийн зардлыг тооцоолохдоо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн "Сонгуулийн сурталчилгаа", 49 дүгээр зүйлийн "Сонгуулийн зардал" хэсэгт үндэслэх бөгөөд сонгуулийн сурталчилгааны арга хэлбэр, нам, эвсэл болон нэр дэвшигчийн сонгуульд зарцуулах зардалтай холбоотой холбогдох зохицуулалтыг нарийвчилж үзнэ. Үүнд:

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны шууд болон шууд бус зардал (цаашид "сонгуулийн зардал" гэх) нь дараах зүйл ангилалтай байна.

Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;

- Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;

- Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;

- Ухуулах байр ажиллуулах;

- Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;

- Цахим орчин ашиглах;

- Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.

Нам, эвсэл, нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусталх хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргах зохицуулалттай.

3.1 Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал;

3.1.1 Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3<sup>4</sup>, 41 дүгээр зүйл "Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх, тараах, хүргэх" гэснийг шалгуур болгон тооцоолно.

Аргачлал: Нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны сонин, сэтгүүл, ухуулах буюу зурагт хуудас, Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн хэвлэмэл материал хэвлүүлэх зардлуудыг тус бүр 3-аас доошгүй байгууллагын үнийн саналыг авч дунджаар тооцно. Харин брайл үсгээр хэвлүүлэх зардлыг нам, эвсэл болон нэр дэвшигчийн сонгуулийн

<sup>4</sup> 13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх нийт зардлын 0.4<sup>5</sup> хувиас хэтрэхгүйгээр зардал гаргаж болно.

Сонин, сэтгүүл хэвлүүлэх зардлын тооцоолол /Нэр дэвшигч/:

$$N_C = (n * p), \quad M_C = (n * p)$$

$N_C$  – Сонин хэвлүүлэх зардал  
 $M_C$  – Сэтгүүл хэвлүүлэх зардал  
 $p$  – Хэвлэлийн дундаж үнэ  
 $n$  – тухайн тойргийн өрхийн тоо

Ухуулах буюу зурагт хуудас хэвлүүлэх зардлын тооцоолол /Нэр дэвшигч/:

$$R = q(b * p * s), \quad \begin{cases} b = 2 \\ q \leq 4 \end{cases}$$

$R$  – ухуулах буюу зурагт хуудас хэвлүүлэх зардал  
 $q$  – зурагт хуудсыг хамгийн их солих боломж  
 $b$  – ухуулах буюу зурагт хуудасны тоо  
 $p$  – хэвлэлийн дундаж үнэ  
 $s$  – нэгдсэн самбарын тоо

Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн хэвлэмэл материал хэвлүүлэх зардлын тооцоолол:

$$V = (\theta * p),$$

$V$  – хэвлэмэл материал хэвлүүлэх зардал,  
 $p$  – хэвлэлийн дундаж үнэ,  
 $\theta$  – улсын хэмжээний өрхийн тоо

Нийт сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх зардлын тооцоолол:

$$\sum A_C = V + (N_C + M_C + R)$$

$A_C$  – Сурталчилгааны материалын зардал  
 $N_C$  – Сонин хэвлүүлэх зардал  
 $M_C$  – Сэтгүүл хэвлүүлэх зардал  
 $V$  – хэвлэмэл материал хэвлүүлэх зардал,  
 $R$  – ухуулах буюу зурагт хуудас хэвлүүлэх зардал

### 3.1.2 Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг тараах зардал

Аргачлал: Нам эвсэл болон нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны материалыг хүргүүлэх зардлыг шуудангийн үнэ тарифаар тооцно.

Орон нутагт шуудан хүргэлтийн зардлын тооцоолол:

$$\alpha = x * \delta$$

$\alpha$  – шуудангийн хүргэлтийн зардал,  
 $\delta$  – Илгээлтийн үнэ (5 кг тутамд)  
 $x$  – хайрцагны тоо

3.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дүгээр зүйл “Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах”, 42.2<sup>6</sup>-т зааснаар найман хэвлэлийн

<sup>5</sup> Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Мэдээллийн нэгдсэн сангаас 2022 оны нийт хүн амын тоог хараагүй иргэдийн тоонд харьцуулан гаргасан болно. /<https://www.1212.mn//>

<sup>6</sup> 42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

Аргачлал: Нам, эвсэл нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг 3-аас доошгүй байгууллагын үнийн саналыг авч дунджаар тооцно.

Нам, эвслийн зурагт самбарын зардлын тооцоолол:

$$P_c = (u * p)s$$

$P_c$  – зурагт самбарын зардал,

$p$  – хэвлэлийн дундаж үнэ,

$u$  – хэвлэлийн хэмжээ /м2/

$s$  – самбарын тоо

3.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал  
Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйл “Намын далбааг сонгуулийн сурталчилгаанд ашиглах”, 13 дугаар зүйлийн 13.3<sup>7</sup>, 30 дугаар зүйлийн 30.1<sup>8</sup>, 40 дүгээр зүйлийн 40.1<sup>9</sup>, 45 дугаар зүйлийн 45.1<sup>10</sup> дэх хэсгийг тус тус харгалзана.

Аргачлал: Намын далбааг хэвлүүлэх зардал нь нэр дэвшигчдийн хуулиар зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэлд 1, ухуулах байранд 1, сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд 2 хүртэл, нам эвсэл болон нэр дэвшигчийн уриа, таних тэмдгийн нэр зэргийг тус бүр тооцож 3-аас доошгүй байгууллагын үнийн саналыг авч дунджаар тооцно.

Нэр дэвшигчийн тээврийн хэрэгсэлд ашиглах далбааны тоо:

$$: A_t = \beta * r, \quad r \leq 2^{11} \Rightarrow d_t = A_t * d_p$$

$A_t$  – тээврийн хэрэгсэлд ашиглах намын далбааны тоо

$\beta$  – тухайн тойрогт хамаарах хэсгийн тоо,

$r$  – тээврийн хэрэгслийн тоо

$d_t$  – Тээврийн хэрэгсэлд ашиглах далбааны зардал

$d_p$  – Далбааны дундаж үнэ

Намын уулзалт, хурал цуглаанд ашиглах далбааны тоо

$$U_d = (d * f) * d_p, \quad f \leq 2$$

$U_d$  – Ухуулах байранд ашиглах намын далбааны зардал

$d$  – тухайн тойргийн ухуулах байрны тоо

$f$  – ухуулах байранд байрлуулах намын далбааны тоо,

$d_p$  – далбааны дундаж үнэ

Нам, эвслийн уриа, таних тэмдгийн нэр хэвлүүлэх зардлын тооцоолол

$$U_t = (s_c + (a_n * c_c) + (D * d_c) + (s_x * x_p)) u_p, \quad \text{const} \begin{cases} s_c = 500 \\ c_c = 100, \\ d_c = 50 \\ x_p = 20 \\ a_n = 22 \\ D = 9 \\ s_x = 532 \end{cases}$$

$U_t$  – Уриа, таних тэмдгийн нэр хэвлүүлэх зардал

<sup>7</sup> 13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

<sup>8</sup> 30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.

<sup>9</sup> 40.1.Сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь нь сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

<sup>10</sup> 45.1.Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.

<sup>11</sup> 40.1.Сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь нь сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

$s_c$  – улсын хэмжээнд ажиллах ажилчдын тоо  
 $a_n$  – аймаг, нийслэлийн тоо  
 $c_c$  – аймаг, нийслэлд ажиллах ажилчдын тоо  
 $D$  – дүүргийн тоо  
 $d_c$  – дүүрэгт ажиллах ажилчдын тоо  
 $s_x$  – сум, хорооны тоо  
 $x_p$  – сум, хороонд ажиллах ажилчдын тоо  
 $u_p$  – уриа, тэмдгийн хэвлэлийн дундаж үнэ

Нэр дэвшигчийн уриа, таних тэмдгийн нэр хэвлүүлэх зардлын тооцоолол

$$U_t = d^{12} * u_p$$

$U_t$  – Уриа, таних тэмдгийн нэр хэвлүүлэх зардал  
 $d$  – тухайн тойргийн ухуулагчийн тоо  
 $u_p$  – уриа, таних тэмдгийн хэвлэлийн дундаж үнэ,

#### 3.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь заалтын дагуу “Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд”-үүд нам, эвсэл болон нэр дэвшигчдийн сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй тул сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх үйл ажиллагаанд зардлын дээд хэмжээ тогтоохгүй.

#### 3.5. Ухуулах байр ажиллуулах зардал

Ухуулах байр ажиллуулах зардалд нэр дэвшигчийн дараах зардлууд хамаарна. Үүнд:  
 Ухуулах байрны түрээсийн зардал  
 Ухуулагчийн урамшууллын зардал  
 Тээврийн хэрэгслийн зардал

##### 3.5.1 Ухуулах байрны түрээсийн зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3<sup>13</sup>, 32 дугаар зүйлийн 32.12<sup>14</sup>, 39 дүгээр зүйлийн 39.1<sup>15</sup>, 45 дугаар зүйл “Ухуулах байр ажиллуулах” заалтыг харгалзан тооцоолно.

Аргачлал: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 45.3 дахь хэсэгт заасны дагуу ухуулах байрыг ажиллуулах хугацаа нь сонгуулийн сурталчилгаа хийх хугацаатай ижил байна. Тухайн тойрогт хамрагдах сонгогч болон хэсгийн тоонд үндэслэн байрны түрээсийг орон нутаг, нийслэлд ялгаатай тогтоох бөгөөд зах зээлийн үнэ ханшийг харгалзан тогтооно.

Нийслэл болон орон нутагт ухуулах байрны түрээсийн зардлын тооцоолол:

$$O_c = (E * p) * T, \quad O_l = (E * p) * T, \quad (T \leq 17)$$

$O_c$  – нийслэл дэх байрны түрээсийн зардал  
 $O_l$  – орон нутаг дах байрны түрээсийн зардал  
 $E$  – тухайн тойргийн ухуулах байрны тоо,  
 $p$  – байрны түрээсийн дундаж үнэ  
 $T$  – сонгуулийн сурталчилгааны хоног

##### 3.5.2 Ухуулагчийн урамшууллын зардал

<sup>12</sup> 37.3.Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежер, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо, аймгийн төвийн баг тус бүрд нэг шадар туслагч, нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно.

<sup>13</sup> 13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

<sup>14</sup> 32.12.Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ.

<sup>15</sup> 39.1. Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3<sup>16</sup>, 37.8<sup>17</sup> дах заалт болон Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг шалгуур болгон тооцоолно.

Аргачлал: Ухуулагчийн урамшууллын зардлыг тухайн тойрогт хамрагдах сонгогчийн тоонд үндэслэн нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байхаар нэр дэвшигчид тооцох бөгөөд хуульд заасны дагуу ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрүүлэхгүйгээр тооцоолно.

Нийслэл болон аймгийн төвд ажиллах ухуулагчийн урамшууллын тооцоолол:

$$\sum A_s = (d * L)0.5);$$

Бусад газар буюу сумын төвд ажиллах ухуулагчийн урамшууллын тооцоолол:

$$\sum A_s^* = (d * L)0.5);$$

$A_s$  – ухуулагчийн урамшууллын нийт дүн

$d$  – тухайн тойргийн ухуулагчийн тоо,

$L$  – хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ,

### 3.5.3 Тээврийн хэрэгслийн зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 36 дугаар зүйл “Сонгууль эрхэлсэн байгууллага”, 37 дугаар зүйл “Сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн”-ийн 37.1, 37.2, 37.3, 40 дүгээр зүйл “Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах”-ийг тус тус шалгуур болгон тооцоолно. Мөн Зам тээврийн, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1, 3-р хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”-ийн 12.4-т заасан хэмжээг үндэслэнэ.

Аргачлал: Тээврийн хэрэгслийн өдөрт зарцуулах зардлын хэмжээг тогтоохдоо аймаг, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлэн тээврийн хэрэгслийг ашиглах тул тухайн тойрогт боломжит туулах замыг суурин газарт гэж тооцож 60 км/цагийн хурдтай, өдөрт ажлын 8 цаг, 100 км-т дунджаар 20 литр шатахуун зарцуулан гэж тооцоолно.

Тээврийн хэрэгслийн зардлын тооцоолол:

$$A = \frac{((G_p * G_l) T) r}{m}, \quad const \begin{cases} V = 60 \text{ км/ц} \\ t = 8 \text{ ц} \\ G_l = 96 \text{ л} \\ T \leq 17 \\ r \leq 2 \end{cases}$$

$A$  – тээврийн хэрэгслийн зардал,

$V$  – тээврийн хэрэгслийн хурд

$t$  – нэг өдөрт зарцуулах цаг

$G_p$  – шатахууны дундаж үнэ,

$G_l$  – өдөрт зарцуулах шатахууны хэмжээ,

$T$  – сонгуулийн сурталчилгааны хоног,

$r$  – тухайн тойргийн тээврийн хэрэгслийн тоо

$m$  – тухайн тойргийн мандатын тоо

### 3.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн холбогдох зохицуулалтыг шалгуур болгон тооцоолно.

Аргачлал (Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч): Радио, Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн сурталчилгаа нэвтрүүлэх зардлыг тогтоохдоо радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн үнийн саналын арифметик дундаж үнэ, сонгуулийн сурталчилгааны хоног, нэвтрүүлгийн хоногт ногдох хугацаа, нийт сурталчилгаа нэвтрүүлэх

<sup>16</sup> 37.3.Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежер, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо, аймгийн төвийн баг тус бүрд нэг шадар туслагч, нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно.

<sup>17</sup> 37.8.Ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.

радио, телевизийн тоо (Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө бүртгүүлэх хуулийн зохицуулалтай тул УИХ-ын 2020 оны сонгуулиар нэвтрүүлэг явуулсан Радио, Телевизийн тоог харгалзаж үзнэ) зэргийг харгалзан тооцно.

Телевизээр сурталчилгаа нэвтрүүлэх зардал. /нам, эвсэл/

$$B_C = \frac{(bp \cdot t \cdot T) \cdot tv}{mt}, \quad \text{const} \begin{cases} t \leq 15 \\ T \leq 17 \\ tv = 18 \end{cases}$$

$B_C$  – нэвтрүүлэх зардал,  
 $bp$  – нэвтрүүлэх дундаж үнэ,  
 $t$  – минут  
 $tv$  – телевизийн тоо  
 $T$  – сонгуулийн сурталчилгааны хоног  
 $mt$  – нийт мандатын тоо

Телевизээр сурталчилгаа нэвтрүүлэх зардал. /нэр дэвшигч/

$$B_C = \frac{(bp \cdot t \cdot T) \cdot tv}{m}, \quad \text{const} \begin{cases} t \leq 15 \\ T \leq 17 \end{cases}$$

$B_C$  – нэвтрүүлэх зардал,  
 $bp$  – нэвтрүүлэх дундаж үнэ,  
 $t$  – минут  
 $tv$  – телевизийн тоо  
 $T$  – сонгуулийн сурталчилгааны хоног  
 $m$  – тухайн тойргийн мандатын тоо

Радиоогоор сурталчилгаа нэвтрүүлэх зардал. /нам, эвсэл/

$$R_C = \frac{(rp \cdot t \cdot T) \cdot rt}{mt}, \quad \text{const} \begin{cases} t \leq 15 \\ T \leq 17 \end{cases}$$

$R_C$  – радиоогоор нэвтрүүлэх зардал,  
 $rp$  – нэвтрүүлэх дундаж үнэ,  
 $t$  – нэг нам эвсэл, бие даан нэр дэвшигчид ногдох хугацаа  
 $rt$  – радиогийн тоо  
 $T$  – сонгуулийн сурталчилгааны хоног  
 $mt$  – нийт мандатын тоо

Радиоогоор сурталчилгаа нэвтрүүлэх зардал. /нэр дэвшигч/

$$R_C = \frac{(rp \cdot t \cdot T) \cdot rt}{m}, \quad \text{const} \begin{cases} t \leq 15 \\ T \leq 17 \end{cases}$$

$R_C$  – радиоогоор нэвтрүүлэх зардал,  
 $rp$  – нэвтрүүлэх дундаж үнэ,  
 $rt$  – радиогийн тоо  
 $t$  – нэг нам эвсэл, бие даан нэр дэвшигчид ногдох хугацаа  
 $T$  – сонгуулийн сурталчилгааны хоног  
 $m$  – тухайн тойргийн мандатын тоо

### 3.7. Цахим орчин ашиглах зардал

Шалгуур: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйл “Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах”-ийн холбогдох зохицуулалтыг шалгуур болгон тооцоолно. Мөн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.12-т заасан хязгаар болон тухайн тойргийн нийт сонгогчийн тоо, дундаж зардлыг шалгуур болгон тооцож болно.

Аргачлал: Нам, эвсэл болон нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг Сонгуулийн сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглаж болно. Үүнд:

Цахим хуудас (Домайн нэр<sup>18</sup>+веб хостинг<sup>19</sup>)  
Олон нийтийн сүлжээний цахим хуудас /Фейсбүүк, Твиттер, Инстаграм олон нийтийн сүлжээний цахим хуудас гэх мэт хамаарна./

Бусад цахим хуудас.

Цахим хуудастай холбоотой мэдээллийн веб үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд болон цахим хуудсаар үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй байгууллагын үнийн саналын дунджаар тооцно.

Цахим хуудасны зардал

$$W_C = (D_C + W_h)$$

$W_C$  – цахим хуудасны зардал  
 $D_C$  – Домайн нэр үүсгэх зардал,  
 $W_h$  – Хост хийх зардал

Бусад цахим хуудасны зардал

$$OW_C = (BN_C * WB_C) * T \quad \text{const} \begin{cases} T \leq 17 \\ WB_C = 5 \end{cases}$$

$OW_C$  – Бусад цахим хуудасны зардал

$BN_C$  – Баннерт байршуулах зардал,

$WB_C$  – Вэбсайтын тоо

$T$  – сонгуулийн сурталчилгааны хоног

3.8. Нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах нийт зардлын дээд хэмжээ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дах заалтын дагуу Сонгуулийн сурталчилгаа явуулах арга, хэлбэр тус бүрээр аргачлалын дагуу тооцож нийт зардлын дээд хэмжээг дараах дараах томъёоллын дагуу тооцно.

### Дөрөв. Бусад зүйл

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох энэхүү аргачлал нь сонгуулийн тухай хууль тогтоомж болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон зарчим, үндсэн зорилтод нийцсэн байна.

Энэхүү аргачлалын дагуу Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо хараат бус түвшний бодитой нотлох зүйлсэд тулгуурласан хэм хэмжээг дагаж мөрдөх бөгөөд хууль тогтоомжид заасан зардлын зүйл, ангилал арга хэлбэрт хязгаарлагдана.

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтооход шаардлагатай үндсэн мэдээлэл, түүний боловсруулалт, баталгаажуулалт болон үнэн зөв, бодитой, хүчин төгөлдөр байдлыг мэдээлэл хариуцсан бүх шатны төрийн байгууллага хууль тогтоомжийн дагуу хариуцна.

---o0o---

<sup>18</sup> “Домэйн нэр” гэж интернэтийн нөөцийн хаягийг тодорхойлох тухайн улсад тусгайлан олгосон үсэг, тоо, бусад таних тэмдгийн хослолыг.

<sup>19</sup> Хостинг сервер гэдэг нь вебийг интернетэд байрлуулах веб серверээр хангах үйлчилгээ юм.